



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 4/64

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид эрүүл мэндийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх журам"-ыг нэгдүгээр, "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Журмыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв (Г.Ууганцэцэг), Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжлийн салбар зөвлөл (З.Хишигсүрэн), Сэргээн засах судлалын мэргэжлийн салбар зөвлөл (А.Балжинням)-д, хариуцсан чиг үүргийн хүрээнд хэрэгжилтийг хангаж ажиллахыг газар, хэлтсийн дарга нарт тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газар (М.Наранпүрэв)-т үүрэг болгосугай.

5. Энэ журам гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 462 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ж.ЧИНБҮРЭН

141260335

Эрүүл мэндийн сайдын 2026 оны 02
дугаар сарын 26-ны өдрийн 1/64 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИД СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид (цаашид "хохирогч" гэх) сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулна.

1.2.Хохирогчид Хүн худалдаалахтай тэмцэх тухай, Эрүүл мэндийн тухай хууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хүрээнд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

1.3.Хохирогчид сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан "Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам" болон оношилгоо, эмчилгээ, үйлчилгээ үзүүлэхэд баримтлах стандарт, заавар, зөвлөмжийг баримтална.

1.4.Насанд хүрээгүй хохирогчийн сэтгэл зүйн онцлогт чиглэсэн сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ, үйлчилгээг сэтгэл заслаар мэргэшсэн ерөнхий эсвэл хүүхэд өсвөр үеийн сэтгэцийн эмч, тусгай бэлтгэгдсэн мэргэжилтэн, сэтгэл зүйч үзүүлнэ.

1.5.Хохирогчид сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хуульд зааснаас бусад тохиолдолд түүний зөвшөөрлийг, насанд хүрээгүй, хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал, сэтгэцийн эмгэгтэй, хэлний бэрхшээлтэй, эрх зүйн хязгаарлагдмал чадамжтай хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэрч, хохирогчийг хамгаалах байгууллагын албан ёсны төлөөлөгчийн оролцоотой зөвшөөрлийг бичгээр авна.

Хоёр.Хохирогчид сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим

2.1.Хохирогчид сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд дараах зарчмыг баримтална:

- 2.2.1. хүний эрх болон нэр төрийг хүндэтгэх;
- 2.2.2. ялгаварлан гадуурхахгүй байх;
- 2.2.3. аюулгүй байдлыг хангах;
- 2.2.4. хор хохирол учруулахгүй байх;
- 2.2.5. гэмтлийн талаарх мэдээлэлд суурилсан, хохирогчид чиглэсэн, жендерийн мэдрэмжтэй үйлчилгээ үзүүлэх;
- 2.2.6. хохирогчийг буруутгахгүй байх;
- 2.2.7. хохирогчийн хувийн болон эрүүл мэндийн мэдээллийг хамгаалах;
- 2.2.8. хохирогчийн онцлог хэрэгцээг тогтоож, тохирсон тусламж, үйлчилгээг үзүүлэх;
- 2.2.9. хүнлэг, энэрэнгүй, ёс зүйтэй байх.

Гурав.Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

3.1.Хохирогчид сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг дараах чиглэлээр үзүүлнэ:

- 3.1.1.сэтгэл зүйн анх удаагийн ярилцлага;
- 3.1.2.сэтгэлзүйн оношилгоо;
- 3.1.3.хохирогчийн сэтгэл зүйг өдөр тутам хянах;
- 3.1.4.ганцаарчилсан ярилцлага, зөвлөгөө;
- 3.1.5.багийн эмчилгээ.

3.2. Сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг хохирогчийн оршин сууж байгаа нутаг дэвсгэрийн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв үзүүлнэ.

- 3.2.1. Хохирогчийг сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд хамруулах ажлыг цагдаагийн байгууллага, эсхүл хамгаалах байрны захиргаа, эсхүл хууль болон гэрээгээр үүрэг хүлээсэн бусад байгууллага, албан тушаалтан шуурхай зохион байгуулна.
- 3.2.2. Хохирогчийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох, сэтгэцийн эмгэгийг илрүүлэх, оношлох, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сэтгэл засал эмчилгээ хийх, сэтгэцийн эмгэг үүсэхээс урьдчилан сэргийлэх, эмчилгээнд хяналт тавина.
- 3.2.3. Хохирогчийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлоход түүний гэр бүлийн болон амьдралын нөхцөл байдал, эрүүл мэндийн болон өвчний түүхийг судалж, сэтгэцийн эрүүл мэндийн тандах асуулга, үнэлэх хуудас зэргийг ашиглана. Шаардлагатай тохиолдолд хохирогчийн гэр бүлийн гишүүн, найз зэрэг бусад хүнтэй ярилцлага хийж, анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэхэд тэдний дэмжлэгийг авна.
- 3.2.4. Хохирогчийн сэтгэцийн сэргээн засалтын төлөвлөгөөг 2–4 долоо хоног тутам дахин үнэлж, хэрэгцээний өөрчлөлтөд нийцүүлэн шинэчилж, дараачийн шатлал руу шилжүүлэх бол лавлагааны хуудас заавал бөглөж, хүлээн авагч тал баталгаажуулна.
- 3.2.5. Хохирогчийн сэтгэцийн эмгэгийн эмнэл зүйн шинжүүд зургаан сараас дээш хугацаагаар үргэлжилсэн, эсхүл сэтгэцийн эмгэг даамжран архагшсан, хөдөлмөрийн чадварыг алдагдуулах болон хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэлт нөхцөл үүссэн, анхан шатны тусламж, үйлчилгээ үр дүнд хүрээгүй тохиолдолд аймаг, дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, эсхүл Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд илгээнэ.
- 3.2.6. Ерөнхий болон сэтгэл заслаар мэргэшсэн сэтгэцийн мэргэжлийн эмч, сэтгэл зүйчийн дэмжлэг, туслалцааг авч, хамтран ажиллана.

3.3.Аймаг, дүүргийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв нь хохирогчид сэтгэцийн эрүүл мэндийн дараах тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

- 3.3.1. Хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөө өгч, сэтгэл заслын болон эмийн эмчилгээ хийнэ.

3.3.2. Хохирогчийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг харгалзан анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтад илгээнэ.

3.4. Хохирогчид анхан болон аймаг, дүүргийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв нь сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн боловч үр дүнд хүрээгүй, эсхүл хохирогч сэтгэцийн эмгэгийн улмаас өөрийгөө хянах чадваргүй болж өөрийн буюу бусдын амь нас, нийгэмд хор хохирол учруулах үйлдэл хийсэн, эсхүл хийх эрсдэлтэй тохиолдолд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд илгээнэ.

Дөрөв. Хохирогчид сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлага

4.1. Хохирогчид сэтгэцийн эрүүл мэндийн бүх шатны тусламж, үйлчилгээ үзүүлэхэд дараах нийтлэг хэм хэмжээг мөрдөнө.

- 4.1.1. үйлчлүүлэгчийн сэтгэцийн эрүүл мэндийг тодорхойлох, оношлох, сэргээн эмчлэхэд шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлнэ.
- 4.1.2. хохирогчтой хийх уулзалт, ярилцлагыг хаалттай буюу бусад хүнд сонсогдохгүй орчин нөхцөлд ганцаарчлан явуулах бөгөөд хохирогчтой ижил хүйсийн эмч, сэтгэл зүйчийг ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 4.1.3. үр дүнтэй харилцаа үүсгэхийн тулд хохирогчийн сэтгэл зүйн онцлог, бусад нөхцөл байдлыг харгалзан үзэж уулзалт, ярилцлагын асуулт, сэтгэцийг тодорхойлоход шаардлагатай асуулт, сорил зэрэг бусад хэрэглэгдэхүүнийг урьдчилан бэлтгэнэ.
- 4.1.4. сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын эмчилгээ, бусад шаардлагатай туслалцаа, үйлчилгээг үр дүнтэй үзүүлэхийн тулд хохирогчийг тэвчээртэй сонсож, түүний сэтгэцийн болон бусад нөхцөл байдлыг ойлгоход шаардлагатай орчин, цаг хугацааг урьдчилан төлөвлөнө.
- 4.1.5. сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үеийн бүхий л мэдээллийн нууцыг хадгалах бөгөөд зөвхөн түүний зөвшөөрлийн үндсэн дээр аюулгүй байдлыг хангах, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд нууцлалыг хадгалах нөхцөлтэйгөөр танилцуулж, ярилцлагын тэмдэглэлд энэ тухай тусгаж, гарын үсэг зуруулна.

Тав. Талуудын хамтын ажиллагаа

5.1. Сэтгэцийн эрүүл мэндийн бүх шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага, эмч, сэтгэл зүйч нь хохирогчийн олон талт хэрэгцээ, ашиг сонирхлыг тодорхойлоход шаардлагатай арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэх бөгөөд хохирогчийг нийгмийн идэвхтэй гишүүн болж нийгэмших, амьдралын чанарыг нь нэмэгдүүлэхэд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар үүрэг хүлээсэн төрийн байгууллага, албан тушаалтан болон иргэний нийгмийн байгууллага, хохирогчийн гэр бүл, бусад этгээдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх зэргээр идэвхтэй хамтран ажиллана.

5.2. Сэтгэцийн эмгэгтэй болох нь тогтоогдсон хохирогч хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбогдуулан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад

холбогдох төрийн байгууллагад тайлбар, мэдүүлэг өгөхөд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эмч, сэтгэл зүйч шаардлагатай тохиолдолд, эсхүл хохирогчийн хүсэлтээр байлцаж шаардлагатай мэргэжлийн тусалцаа, үйлчилгээ үзүүлнэ.

5.3.Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад хохирогч хүн худалдаалах болон бусад эрүүгийн хэргийн хохирогч болох эрсдэлтэй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд энэ тухай цагдаагийн байгууллагад шуурхай мэдээлнэ.

Зургаа. Санхүүжилт

6.1.Хохирогчид үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 18.1.5, 18.1.9-д заасны дагуу тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар санхүүжүүлнэ.

Долоо. Бусад зүйл

7.1.Энэ журмыг зөрчсөн бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---